

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

Ц.ТУЛГА

**НУТГИЙН ЗАХИРГААНЫ ЦОГЦОЛБОРЫН КОНЦЕПЦ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2018 оны 02-р сарын 20-ний өдөр	Дугаар №	Улаанбаатар хот
1	Концепц боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/11 дугаар тушаал;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр /Хавсралт-1/ - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээр 2015 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 198 дугаар тогтоолоор батлагдсан “Нисэх Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний” дагуу; - Төлөвлөлтийн талбай 5.0 га
3	Зориулалт, хүчин чадал	- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн танхим; - Нийслэлийн Засаг даргын тамгын газар - Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба; - Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг; - Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар; - Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв; Нийт 2000 орчим албан хаагч;
4	Одоогийн байдал	- Төлөвлөж буй талбай нь Хотын төвөөс /Сүхтбаатарын талбай/ 10 км-т, хойд хэсгээрээ яармагийн гэр хороолол, урд хэсгээрээ БогдХан уул Дархан цаазат газар нутгаар хүрээлсэн байршилтай; - Концепц боловсруулах талбай одоогоор барилгажилгажаагүй бөгөөд 7, 8 баллын газар хөдлөлийн бүсэд оршдог;
5	Концепц гүйцэтгэх хугацаа	- 2018 оны 02 дугаар сарын 22-ний өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 08-ний өдөр;
6	Концепцийн захиалагч	- Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар;
7	Концепц боловсруулах байгууллага	- Мэргэжлийн сургууль төгсөөд 5 хүртэл жил болсон залуу архитектор - Мэргэжлийн сургуулийн оюутнууд оролцоно.
8	Концепц боловсруулах үе шат	- Уралдаан сонгон шалгаруулалт I үе шаттай;
9	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Орчин үеийн хэв маяг болон үндэсний онцлогтой Улаанбаатар хотын шинэ дүр төрх бүхий цогцолбор байхаар боловсруулах; - Байршил газар зүйн онцлог байдлыг тодорхойлох; - Цогцолбор барилгын орон зайн төлөвлөлтийн шийдэл; - Цогцолбор барилгын гадна дизайн шийдэл; - Тохижилтын шийдэл; - Хөдөлгөөний схем; - Байгаль ээлтэй, ашиглалтын зардал багатай дэвшилтэт технологи бүхий эко шийдлийг тусгах;

10	Концепцийн иж бүрдэл	<p><u>Иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нүүр хуудас; - Тайлбар бичиг; - Орчны тойм; - Одоогийн байдал /фото/; - Төлөвлөлтийн концепц шийдэл; - Ерөнхий төлөвлөгөө шийдэл; - Хөдөлгөөний схем; - Явган хүний хөдөлгөөн схем; - Ногоон байгууламжийн шийдэл; - Харагдах байдал; - Модель макет /сонголтоор/ - Бусад; <p>Уралдаанд нэг оролцогч хэдэн ч бүтээл ирүүлэх боломжтой. Мөн оролцогч бүтээл тус бүрт өөрийн нэр, холбоо барих утас, хаягийг тодорхой мэдээллэсэн байна. Концепц төсөл зохиогч нь гараар эсвэл компьютер график ашиглан боловсруулах;</p> <p>A3 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.pdf, *.jpg, *.png / товч тайлбар, танилцуулга A4 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.doc, *.pdf/</p>
11	Онцгой нөхцөл	- Засаг, захиргааны бүтэц тэдгээрийн уялдаа холбоог хангасан байх;

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

..... /Т.ГАНЗОРИГ/

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН

..... /Г.ХОСБАЯР/

БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН
ОРЛОГЧ ДАРГА Ц.ТУЛГА

НУТГИЙН ЗАХИРГААНЫ ЦОГЦОЛБОРЫН КОНЦЕПЦ БОЛОВСРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” хот байгуулалтын бодлогын баримт бичиг батлагдсан.

Улаанбаатар хотын хот байгуулалтын үйл ажиллагааг 35206.0 га талбайд төлөвлөж, хилийн цэсийн гадна байрлах ногоон бүсийг хамгаалалтын захиргаа, хууль тогтоомжтой нийцүүлэн хөгжүүлэхээр тусгагдсан. Хот байгуулалтын үйл ажиллагааг дэмжих нутаг дэвсгэрийг хот төлөвлөлтийн 8 бүсэд хувааж хотын зэрэглэлтэй 2 дэд төв, дүүргийн зэрэглэлтэй 6 дэд төвтэй нэг төвт хотоос олон төвт хот болон хөгжүүлэхээр тусган төлөвлөлтийн бүс нь өөрийн засаг захиргаа, орон сууц , олон нийт, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ бүхий төвүүдтэй /хотын төв, дэд төв/ байхаар төлөвлөн цаашид 8 бүсэд 2020 он гэхэд нийт 1,235.6 мянган хүн ам оршин суурьшихаар төлөвлөгдсөн.

Уг зорилтын хүрээнд Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун өмнөд бүсэд хотын шинэ төвийг байгуулах ажлын хүрээнд “Нутгийн захиргааны цогцолбор”-ын концепц боловсруулах уралдааныг зарлаж байна.

1.2. Үндэслэл

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1-д “Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвийн дэд бүтцийг байгуулж, Яармаг, Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвийн ажлыг эхлүүлэх” заалтыг үндэслэн боловсруулав.

1.3. Зорилго

Улаанбаатар хотын төв хэсэгт /Их Тойруу орчим/ хүн ам, худалдаа, үйлчилгээний урсгал, төвлөрлийг сааруулах зорилгоор Улаанбаатар хотын Баруун өмнөд бүсэд хотын шинэ төвийг байгуулах ажлын хүрээнд “Нутгийн захиргааны цогцолбор”-ийг байгуулах

1.4. Уралдааны хамрах хүрээ

Мэргэжлийн сургууль төгсөөд 5 хүртэл жил болсон архитектор, мэргэжлийн сургуулийн оюутнуудыг оролцуулна.

1.5. Уралдааны хугацаа

Уралдааныг 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 08-ны өдөр хүртэл нэг үе шаттай явуулна.

ХОЁР. УРАЛДААНЫ БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Бүтээлд тавигдах шаардлага

- ✓ Үндэсний онцлог, түүх, байгаль, уламжлалт хэв шинж ахуй амьдралыг тусгасан байх
- ✓ Ирээдүйн хөгжлийн чиг хандлага, олон нийтийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн билэгдэлтэй байх
- ✓ Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдлийг тусгасан байх

- ✓ Орчин үеийн дэвшилтэт технологийг тусгасан эрчим хүчний хэмнэлттэй байх
- ✓ Олон нийтэд ойлгомжтой, зориулалт нь танигдахуйц байх
- ✓ Олон улсын норм стандартыг дагуу тооцож төлөвлөсөн байх
- ✓ Гадна авто зогсоолыг нормын дагуу төлөвлөх
- ✓ Архитекторын ёсзүйн тавигдах шаардлагыг хангах
- ✓ Уралдаанд нэг оролцогч хэдэн ч бүтээл ирүүлэх боломжтой
- ✓ Бүтээл тус бүрт утга агуулга, зураглалын тайлбар, өнгөний код бүхий товч танилцуулгыг хавсаргаж ирүүлэх
- ✓ Оролцогч бүтээл тус бүрт өөрийн нэр, холбоо барих утас, хаягийг тодорхой мэдээллэсэн байна

2.2. Иж бүрдэл

- ✓ Зураглалын иж бүрдэл А3 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.pdf, *.jpg, *.png/
- ✓ Товч тайлбар, танилцуулга А4 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.doc, *.pdf/

2.3. Зохиогчийн эрх

- ✓ Шагналт байранд шалгарсан бүтээлийн зохиогчийн эрх нь уралдаан зарласан зохион байгуулагч талд үлдэх ба цаашид ашиглах, хөгжүүлэх онцгой эрхийг зохион байгуулагч эдэлнэ.
- ✓ Шагналт байранд шалгараагүй бусад бүтээлийг бусад хувь хүн, байгууллагад худалдах, шилжүүлэх, хувилан олшруулах, бусад хэлбэрээр ашиглуулахгүй байх үүргийг санаачлагч, зохион байгуулагч тал бүрэн хариуцна.
- ✓ Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд зохион байгуулагчдын архивт үлдэнэ.
- ✓ Уралдаан дууссаны дараа шагналт байранд шалгарсан бүтээлийн зохиогчтой гэрээ хийж зохиогчийн эрхийг шилжүүлж авах бөгөөд зохиогчийн эрхийг зөвшөөрөөгүй бүтээлийг шагналт байранд шалгаруулахгүй, шалгарсан тохиолдолд шагналыг олгохоос татгалзаж, бусад бүтээлийг шалгаруулна.

2.4. Бүтээлд хориглох зүйлс

- ✓ Удирдамжид заасан шаардлагыг хангаагүй бүтээл ирүүлэхгүй байх
- ✓ Зохиогчийн эрхтэй бусдаас хуулбарласан бүтээл ирүүлэхгүй байх
- ✓ Садар самууныг сурталчилсан утга агуулгатай бүтээл ирүүлэхгүй байх

2.5. Бүтээл ирүүлэх

Уралдааны материалыг: Бүтээлээ дугтуйнд хийж битүүмжлэн доорх хаягаар ирүүлнэ.

- ✓ Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, хичээлийн II дугаар байр, Барилга, Архитектурын сургууль, Архитектурын тэнхим, 5 давхар 504 тоот

ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

3.1. Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын даргын тушаалаар томилогдсон архитектурын салбарын багш, архитектор, зохион байгуулагч нарын төлөөлөл бүхий комиссын гишүүд нийт 10 шалгуур үзүүлт тус бүрээр 0-10 хүртэл бүхэл оноогоор үнэлэх системээр шилдэг 3 бүтээлийг шалгаруулна.

3.2. Шалгуур үзүүлэлт

- ✓ Бүтээлийн үзэл санаа шинэлэг байдал /0-10/ оноо
- ✓ Үндэсний онцлог, түүх, байгаль, уламжлалт хэв шинж ахуй амьдралыг тусгасан байдал /0-10/ оноо

- ✓ Ирээдүйн хөгжлийн чиг хандлага, олон нийтийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн байдал /0-10/ оноо
- ✓ Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал /0-10/ оноо
- ✓ Зориулалтыг нь олон төрлөөр ашиглах боломж, олон нийтэд ойлгомжтой байдал /0-10/ оноо
- ✓ Олон улсын норм стандартыг тооцсон байдал /0-10/ оноо
- ✓ Гадна зам талбай, авто зогсоол, ногоон байгууламж, газар ашиглалтыг оновчтой төлөвлөсөн байдал /0-10/ оноо
- ✓ Архитекторын ёсзүйн шаардлагыг хангасан байдал /0-10/ оноо
- ✓ Бүтээлийн утга агуулга түүнийг бусдад хэрхэн илэрхийлэх, архитектурын график ажиллагаа /0-10/ оноо
- ✓ Бүтээлийн гүйцэтгэл, иж бүрдлийн шаардлагыг хангасан байдал /0-10/ оноо

ДӨРӨВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

- ✓ Тэргүүн байр нэг оролцогч: 3.000.000 /Гурван сая/ төгрөг
- ✓ Дэд байр нэг оролцогч: 2.000.000 /Хоёр сая/ төгрөг
- ✓ Гутгаар байр нэг оролцогч: 1.000.000 /Нэг сая/ төгрөгөөр тус тус шагнаж, батламжилна.

ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

- 5.1.** Оролцогч нар зөвхөн зохион байгуулагч нарт дараах асуудлын хүрээнд гомдол гаргаж болох бөгөөд үүнээс өөр асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.
- ✓ Зохиогчийн эрх зөрчигдсөн асуудлаар */Хувь хүн болон байгууллагын бүтээлийг хуулбарлаж оролцсон. Шалгарсан бүтээл нь ямар нэг улсын болон хотын бүтээлтэй ижил төсөөтэй/*
 - ✓ Шүүгчдийн бүрэлдэхүүнд багтсан гишүүнтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн үед
 - ✓ Шүүгчид бүтээлийн үзэл санааг буруу ойлгож шалгаруулсан
- 5.2.** Гомдлыг шилдэг бүтээлийг шалгаруулж зарласнаас хойш 1 цагийн дотор бичгээр үйлдэж зохион байгуулагчид хүргүүлнэ. Хугацаа хожимдсон болон гомдол гаргасан үндэслэлээ баталгаажуулж хавсаргаагүй гомдлыг хүлээж авахгүй.
- 5.3.** Зохион байгуулагч нь гомдлыг хүлээн авч маш хурдан шийдвэрлэх бөгөөд хариу өгөх хугацааг гомдол гаргагчид урьдчилж мэдэгдэнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг: Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Ерөнхий архитекторын ажлын алба /Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Хангарди ордон, 13 давхар, 1304 тоот/ 11-321943 утсаар болон www.mpa.ub.gov.mn сайтаас лавлана уу.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:


НХТЕТГ-ын Ерөнхий архитекторын ажлын алба

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Монголын Архитекторуудын эвлэл
ШУТИС-ын Барилга, архитектурын сургууль
“СЭЦЭН БЭЙЛ” ХХК

НУТГИЙН ЗАХИРГААНЫ ЦОГЦОЛБОРЫН КОНЦЕПЦ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВРЫН БАЙРШЛЫН СХЕМ

Хэвсгэлт 1



0 0.125 0.25 0.5 0.75 1 Kilometers

Тусгаг : WGS 1984 UTM Zone 46N

Масштаб 1 : 15,000